

## **Маргааны товч**

Татварын улсын байцаагч нараас “Фэн шу зун” ХХК-ийн 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн НА-21220000075 дугаартай нөхөн ногдуулалтын актаар нийт 1,714,159,813.99 төгрөгийн төлбөр төлүүлэхээр тогтоожээ.

“Фэн шу зун” ХХК нь уг актад гомдол гаргах хугацааг сэргээлгэх хүсэлтийг Татварын ерөнхий газрын Маргаан таслах зөвлөлд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр гаргасныг тус зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн албан бичгээр хүлээн авахаас татгалзсан байна.

Нэхэмжлэгчээс “... компанийг төлөөлөх эрхгүй этгээд буюу төлөөлөх бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон этгээдэд нөхөн ногдуулалтын актыг гардуулснаар манай компани нь Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргах эрхээ мэдээгүй, татварын улсын байцаагчийн актад гомдол гаргах хугацаагаа хүндэтгэн үзэх шалтгааны улмаас алдсан ...” гэж;

Хариуцагчаас “... төлөөлөх эрхгүй этгээдэд актыг мэдэгдэж гардуулсан гэх нөхцөл байдал тогтоогдохгүй учир тус компанийн гомдлыг хянан шийдвэрлэх хуулийн хугацааг нөхөн сэргээх хүсэлтийг хүлээн авах үндэслэлгүй ...” гэх агуулгаар тус тус маргажээ.